



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 78,521,910.00 (далан найман сая таван зуун хорин нэгэн мянга есөн зуун арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаа дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ...
дугаар тогтоолын хавсралт

"Өвөрхангай -АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	JAC LMT5061 GLO маркийн битум цацагч	2012	ш	1	58,200,000.00	58,200,000.00	58,200,000.00	0.00
2	АБЗ-ын бутлагч	1987	ш	1	2,651,300.00	2,651,300.00	2,651,300.00	0.00
3	Асфалт зүсэгч хөрөө	2009	ш	1	924,513.00	924,513.00	924,513.00	0.00
4	Дагтаршуулагч	1997	ш	1	2,132,900.00	2,132,900.00	2,132,900.00	0.00
5	Нягтаршуулагч	2005	ш	1	4,329,604.00	4,329,604.00	4,329,604.00	0.00
6	Туузан дамжуулагч	1986	ш	1	243,900.00	243,900.00	243,900.00	0.00
7	Туузан дамжуулагч	1986	ш	1	280,800.00	280,800.00	280,800.00	0.00
8	Услуур	1987	ш	1	150,400.00	150,400.00	150,400.00	0.00
9	уур үүсгэгч	1986	ш	1	8,510,400.00	8,510,400.00	8,510,400.00	0.00
10	Хийн доргиурт алх	2009	ш	1	703,893.00	703,893.00	703,893.00	0.00
11	Ёмкость	1987	ш	1	394,200.00	394,200.00	394,200.00	0.00
				10	78,521,910.00	78,521,910.00	78,521,910.00	0.00
	Нийт хөрөнгийн дүн			10 (арав)	78,521,910.00 (далан найман сая таван зуун хорин нэгэн мянга есөн зуун арван)	78,521,910.00 (далан найман сая таван зуун хорин нэгэн мянга есөн зуун арван)		